

## Автобусны цахим төлбөрийн карт зар

МУИС-ийн МУИС-ийн оюутнуудын автобусаар үнэ төлбөргүй зорчих смарт картны захиалгыг 2017 оны 08 сарын 25-наас 09 сарын 06-ний өдрийг хүртэл хүлээн авах тул удирдамжинд заасан бичиг баримтыг бүрдүүлэн өгнө үү.

### **Шинээр болон дахин захиалах оюутнууд**

- 1-р түвшний оюутнууд

/ 08 сарын 25-30-ны өдрүүдэд болох МУИС-ийн шинэ элсэгчдийг чиглүүлэх сургалтын үеэр захиалах /

- Дахин захиалах 2, 3, 4 дүгээр түвшний оюутнууд

/ 08 сарын 25-30-ны өдрүүдэд болох МУИС-ийн шинэ элсэгчдийг чиглүүлэх сургалтын үеэр захиалах, 8-р сарын 31-нээс 09 сарын 06-ны өдөрийг хүртэл МУИС-ийн салбар сургуулийн мэргэжилтэнүүд болон оюутны албаны мэргэжилтэнүүдэд хандан захиалга өгөх боломжтой/

### **Сунгалт хийлгэх оюутнууд**

/8-р сарын 31-нээс 09 сарын 06-ны өдөрийг хүртэл МУИС-ийн салбар сургуулийн мэргэжилтэнүүд болон оюутны албаны мэргэжилтэнүүдэд хандан сунгалтаа хийлгэх боломжтой

Төлбөрийн карт захиалах хураамж төлөхдөө шинээр болон дахин захиалах бол

- Шинээр болон дахин авахдаа 3600 төгрөгийг УБСК-ийн **Худалдаа Хөгжлийн Банкны 475014869** тоот данс эсвэл **Төрийн Банкны 105700523235** тоот дансанд хураамж төлөх боломжтой.

Сунгалтын төлбөрийн хураамж төлөх бол

- Сунгалтын хураамжийн төлбөр 1000 төгрөгийг зөвхөн УБСК-ийн **Худалдаа Хөгжлийн Банкны 475016875** тоот дансанд тус тус тушаана

Санамж: Цахим төлбөрийн карт шинээр болон дахин захиалах, сунгалт хийлгэхдээ Удирдамжийн /ХАВСРАЛТ-1/-ийг татан авч загварын дагуу бөглөх. Мөн холбогдох бичиг баримтыг үнэн зөв, бүрэн бүрдүүлсэний дараа захиалга өгөх боломжтой.

**МУИС-ОЮУТНЫ АЛБА**